БАТЛАВ.

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ

ДАРГА Б.НЭРГҮЙЦЭЦЭГ

2025 оны 01-р сарын 27-ны өдөр

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ

2025 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.27.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадваxжуулах, урамшуулах үйл ажиллагаа					
1	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах.	Зохион байгуулагдсан сургалтын тоо Хамрагдсан гишүүдийн тоо	2 5	2025.02.01 2025.10.01	Б.Нэргүйцэцэг
2	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системд холбогдож, гишүүдийг бүртгэх.	Системд бүртгэсэн гишүүдийн тоо	5	2025.02.10	О.Болормаа
3	Байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг журмын дагуу олгох санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх.	Урамшуулал олголтын хувь	100	2025.02.01 2025.12.31	Б.Нэргүйцэцэг
Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажил					
4	Color Day өдөрлөг зохион байгуулах. /Төрийн албан хаагчийн хувцаслалт/	Хамрагдсан албан хаагчдын хувь	100	2025.03.21	Б.Нэргүйцэцэг Ёс зүйн дэд хорооны гишүүд
5	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох журмыг албан хаагчдад танилцуулах.	Зохион байгуулах сургалтын тоо Албан хаагчдын хамрагдалтын хувь	2 100	2025.04.04	Б.Нэргүйцэцэг О.Болормаа
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг танилцуулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.04.11	Г.Энхчимэг
7	Байгууллагын соёлыг тодорхойлон батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих.	Байгууллагын соёлын хэрэгжилт, хувь	100	2025.04.01 2025.04.10	О.Болормаа Ёс зүйн дэд хорооны гишүүд

8	Шинэ ажилтныг дадлагажуулах журмыг хэрэгжүүлэх.	Шинээр томилогдсон албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.02.01 2025.12.31	Д.Оюунсайхан Ёс зүйн дэд хорооны гишүүд
9	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулах.	Шинээр томилогдсон албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.02.01 2025.12.31	Б.Нэргүйцэцэг Ёс зүйн дэд хорооны гишүүд
10	Ажлын байрны дасгал, өглөөний уулзалт зохион байгуулах.	Хамрагдсан албан хаагчдын хувь	100	2025.04.25	В.Баярсайхан Ёс зүйн дэд хорооны гишүүд
11	Төрийн албан хаагчдыг ёс зүйн багц цагийн цахим сургалтад хамруулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.02.01 2025.12.31	Д.Оюунсайхан Ёс зүйн дэд хорооны гишүүд
12	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар сургалт зохион байгуулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.05.09	Б.Нэргүйцэцэг
13	Албан хаагчдын дунд “Гэр бүлийн өдөрлөг” зохион байгуулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.05.14	Г.Энхжишиг Ёс зүйн дэд хорооны гишүүд
14	Төрийн албан хаагчийн ажлын байрны эмх цэгцийн талаар сургалт зохион байгуулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.06.28	Г.Энхжишиг
15	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм журмаар АХА тэмцээн зохион байгуулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.11.14	Д.Оюунсайхан Ёс зүйн дэд хорооны гишүүд
16	Албан хаагчдын дунд “Монита” зохион байгуулах.	Албан хаагчдын хамрагдалтын хувь	100	2025.12.01 2025.12.05	Г.Энхжишиг Ёс зүйн дэд хорооны гишүүд
Ёс зүйн зөрчил, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх					
17	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан шалгаж дүгнэлт гаргах.	Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь	100	Тухай бүр	Б.Нэргүйцэцэг Ёс зүйн дэд хорооны гишүүд
18	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн хурлыг улирал тутам, гомдол мэдээлэл ирсэн тохиолдолд тухай бүр хуралдуулах, тэмдэглэл хөтлөх.	Хурлын тоо	4-өөс дээш	2025.01.02 2025.12.31	О.Болормаа

19	Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчтай сонсох ажиллагаа явуулах.	Зөрчил гаргасан албан хаагдын хамрагдалтын хувь	100	Тухай бүр	Б.Нэргүйцэцэг
20	Ёс зүйн зөрчлийн бүртгэлийг, хяналтын дэд системд оруулах.	Ажлын гүйцэтгэл, хувь	100	Тухай бүр	О.Болормаа
21	Ёс зүйн дэд хорооны тайланг хагас, бүтэн жилээр гарган Ёс зүйн хороонд хүргүүлэх.	Хугацаанд нь хүргүүлсэн тайлангийн тоо	2	2025.06.31 2025.12.30	О.Болормаа

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА О.БОЛОРМАА

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”

Нэг. Товч танилцуулга :
Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/17 дугаар тушаалаар байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Засаг даргын Тамгын газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 заалтыг тусган 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/17 дугаар тушаалаар байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөө, тайланг байгууллагын цахим хуудаст байршуулан иргэдэд мэдээлсэн. 2025 онд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй тул дүгнэлт гаргаагүй болно. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгогдоогүй болно.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем /hrm.csc.gov.mn/-д байгууллагын болон ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээлэл, Ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөө тайланг хагас бүтэн жилээр гарган системд байршуулсан. Ёс зүйн дэд хороо 2025 онд төлөвлөгөөний дагуу ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх 11 арга хэжээг зохион байгуулж давхардсан тоогоор 349 албан хаагчдыг хамруулсан. 2025 онд ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй болно.
Гарсан үр дүн, ололт амжилт: Урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай зохион байгуулснаар ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй болно.	**Бэрхшээл:** Аливаа арга хэмжээг зохион байгуулахад санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байна.
Санал:	

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗДТГ-ын дарга
/Албан тушаал/

/Гарын үсэг/

Д.Содном
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

ХЭЗХ-ИЙН ДАРГА /Албан тушаал/ /Гарын үсэг/ Б.НЭРГҮЙЦЭЦЭГ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ХШҮХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Албан тушаал/ /Гарын үсэг/ О.БОЛОРМАА /Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.12.30 Сүмбэр сум

Нэг. Товч танилцуулга :
Говьсүмбэр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллага тус бүр Ёс зүйн дэд хороог 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
Хоёр. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт :
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7, Орон нутгийн өмчийн газарт 11, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газарт 16, Санхүүгийн хяналт дотоод аудитын газарт 9, Хүнс, хөдөө аж ахуйн газарт 9, Шивээговь сумын Засаг даргын Тамгын газарт 7, Баянтал сумын Засаг даргын Тамгын газарт 5, Эрүүл мэндийн газарт 5, Байгаль орчны газарт 8, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 6, нийт 10 байгууллага 83 ажил арга хэмжээг байгууллага бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах, хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор 157,7 сая төгрөгийг батлуулсан. Үүний хүрээнд 2025 онд Монгол Улсын Засгийн газар, Удирдлагын академи болон төрийн бусад байгууллагуудтай хамтран 7 удаагийн сургалт зохион байгуулж, 876 төрийн албан хаагчдыг хамруулсан. Төрийн албан хаагчдын хувийн хэргийн баяжилтыг тухай бүр нь хийж, “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” цахим системд мэдээллийг байршуулж ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Урьдчилсан үзлэг явуулах дэд комиссын бүрэлдэхүүн байгуулах тухай” А/340 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсэг аймаг, сумдын төрийн байгууллагуудад туслах хяналт шалгалтын ажлын зохион байгуулж, төрийн албан хаагчийн хувийн хэргийн баяжилт болон “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” цахим системтэй тулгалт хийж, 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 05/988 дугаартай албан бичгээр “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем дэх бүртгэлийн алдаа зөрчлийг засах, төрийн албан хаагчийн анкетыг баталгаажуулах ажлыг зохион байгуулж биелэлтийг тооцон, Аймгийн Засаг даргын 2025 оны А/434 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 30 байгууллагад хяналт, шинжилгээ, үнэлгээг “Байгууллагын хүний нөөцийн чадамжийн үнэлгээ” хийж батлагдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхойлсон. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэхэд сахилга хариуцлага, ёс зүйн байдлыг харгалзан үнэлж, дүгнэн ажиллаж байна.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийг дэмжих, төрийн албанд шинээр болон сэлгэн, шилжүүлэн томилогдох албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор "Шинэ ажилтныг дадлагажуулах, дасан зохицолын менторшип хөтөлбөр"-ийг Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлийн 2025 оны 35 дугаар тогтоолоор батлан аймгийн хэмжээний төрийн бүх байгууллага хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдад ёс зүйг эрхэмлэн сахих, үлгэрлэн манлайлан ажиллахыг чиглэл болгон ажиллалаа.
Аймгийн Засаг даргын 2025 оны А/434 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 30 байгууллагад биечлэн, 14 байгууллагад цаасан суурьтай тайланд хяналт, шинжилгээ, үнэлгээг "Байгууллагын хүний нөөцийн чадамжийн үнэлгээ" хийж батлагдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхойлсон.
2025 онд нийт 48 сул орон тоог нийтэд зарлаж төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд 5 иргэн, ахлах түшмэлийн удирдах албан тушаалд 3 иргэн, дэс түшмэлийн удирдах албан тушаалд 3 иргэн, дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаалд 11 иргэн нийт 22 иргэн төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж сул орон тоо нөхсөн байна.
Төрийн албаны Ерөнхий шалгалтыг 4 удаа зохион байгуулж 125 иргэн бүртгүүлсэнээс 116 иргэн шалгалтанд оролцож, 37 иргэн тэнцсэн нь нийт оролцсон иргэдийн 31,8 хувийг эзэлж байх бөгөөд сонгон шалгаруулалттай холбоотой гомдол мэдээлэл гараагүй байна.
Томилох эрх бүхий албан тушаалтнаас 4 зөрчилтэй томилгоо хийгдсэнийг хууль, журамд нийцүүлэн зөрчлийг арилгаж ажилласан.
Төрийн байгууллагуудад авлига ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хяналт тавих ажлын хүрээнд авлига ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй албан тушаалын судалгааг гаргаж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг хяналт шалгалтын явцад үүрэг чиглэл болгон ажиллаж байна.
Цаашид төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг эрсдлийн үнэлгээг чанаржуулах, ёс зүйн зөрчлийн талаарх олон нийтийн тандалт судалгаа хийх, хэвлэл, мэдээлэл, судалгаа шинжилгээний байгууллагатай хамтран ажиллаж, иргэдийн үндэсний ашиг сонирхолыг дээшлүүлэх, төрийн байгууллага албан хаагчийн нэр хүндийг нэмэгдүүлэхийг зорилго болгон ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

2025 онд 3 байгууллагын 3 албан хаагчид холбогдох ёс зүйн зөрчил үүссэн байж болзошгүй гомдол мэдээлэл ирүүлснийг холбогдох байгууллагын ёс зүйн дэд хороодод шилжүүлэн ажиллаж, дүгнэлт, шийдвэрийг гаргуулсан. Байгууллага бүр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дотооддоо 2-5 удаагийн сургалт зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөл, Аймгийн Засаг даргын Тамгын газраас хамтран төрийн албан хаагчдыг чадавхижуулах сургалт, нөлөөллийн ажил арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллалаа.
Аймгийн хэмжээнд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд 82,5 хувьтай байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2025.12.30

СҮМБЭР СУМ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	ХХААГ	СХДАГ	ОНӨГ	Сүмбэр сумын ЗДТГ	БОГ	Баянтал сумын ЗДТГ	Шивээговь сумын ЗДТГ	АЗДТГ	ЭМГ	АИТХ	Нийт үнэлгээ	Дундаж үзүүлэлт	Хувийн жин
1	2	3		4	1	2	3	4	5	6	7	8	9	10	5	6	7.0
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх		1	1		1	1	1	1	1	0.7	1	1	9.7	1.0	9.7
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	1	1	1	1	1	1	1	1	0	0	8	0.8	8.0
3		төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	4.5	0.5	4.5
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	4.5	0.5	4.5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	0	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.3	0	0.5	3.8	0.4	3.8
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	0.5	0.5	0.5	0	0.5	0.5	0	0.5	0.5	4	0.4	4.0
Хэсгийн оноо				**4**	**4**	**3.5**	**4**	**4**	**3.5**	**4**	**3**	**3**	**2.5**	**3**	**34.5**	**3.5**	**34.5**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн маналайлал	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх (гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	1.0	10.0
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	10	1.0	10.0
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	0	0	1	0	0	0	0	0	0	2	0.2	2.0
Хэсгийн оноо				**3**	**3**	**2**	**2**	3	**2**	**2**	**2**	**2**	**2**	**2**	**22.0**	**2.2**	**22.0**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	1	1	1	1	0	0	1	1	1	8	0.8	8.0
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал (гомдол ирээгүй бол)		1	1	1	0	1	1	1	1	1	1	1	9	0.9	9.0
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	1	1	1	1	1	1	1	1	1	1	9	0.9	9.0
Хэсгийн оноо				**3**	**3**	**3**	**2**	**3**	**3**	**2**	**1**	**3**	**3**	**3**	**26**	**2.6**	**26.0**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**100**	**85**	**80**	**100**	**85**	**80**	**60**	**80**	**75**	**80**	**825**	**82.5**	**82.5**

ҮНЭЛГЭЭ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Т.ХҮСЛЭН

ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Д.СОДНОМ

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажилласнаар ёс зүйн зөрчил үйлдсэн болон ажлаас чөлөөлөгдсөн тохиолдол байхгүй байна.	Төрийн албан хаагчдад сургалт, нөлөөллийн ажил, арга хэмжээ зохион байгуулахад төсвийн хүрэлцээгүй байдал нь аливаа ажил арга хэмжээг зохион байгуулахад бэрхшээлтэй байна.
Санал:	
Байгууллагын хэмжээнд албан хаагчийн тоо цөөн тохиолдолд ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах боломжгүй нөхцөл байдал үүсч байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж зааврааар хангаж, зохион байгуулалтыг сайжруулахад нэгдсэн чиглэл, зохион байгуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх, ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал, үйл ажиллагааны зардлын асуудлыг хууль тогтоомжид нарийвчлан тусгуулах саналтай байгаа бөгөөд энэ нь Ёс зүйн дэд хорооны хараат бус бие даасан байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байгааг уламжилж байна.	

Шалгах хэсэг:

Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн эсэх,

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх

Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

ЗДТГ дарга		Д. Сайнсэл
/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга

Аз жаргалант хууль, эрх зүйн	мэргэжлийн дарга	Б. Нэргүйсүрэн
/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

хүний		О. Болормаа
/Албан тушаал/	/Гарын үсэг/	/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 дугаар сарын 06-ны өдөр.